



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 сны 08 сарын 30 өдөр

Дугаар А1312

Улаанбаатар хот

Ойгоос хуш модны самар бэлтгэж  
ашиглахыг бүсчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.5, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хуш модны самрыг ахуйн зориулалтаар бэлтгэж ашиглах аймаг, сум, улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ойн бодлого зохицуулалтын газар /Б.Оюунсанаа/, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар /Ч.Батсансар/, Ойн судалгаа, хөгжлийн төв /Д.Мөнхбат/ нарт тус тус үүрэг болгосугай.


3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хуш модыг хамгаалах, нөхөн сэргээх болон ойн санд самар бэлтгэлийн хамгаалалттай бүс байгуулах, технологийг боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгуулан, хэрэгжүүлэхийг Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Төв, Завхан, Хөвсгөл, Увс, Хэнтий аймгийн болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт тус тус зөвлөсүгэй.



САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн  
41312 дугаар тушаалын хавсралт



ХУШ МОДНЫ САМРЫГ АХУЙН ЗОРИУЛАЛТААР  
БЭЛТГЭХ АЙМАГ, СУМ, УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ  
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААДЫН НЭРС

№	Аймаг болон УТХГ-ын хамгаалалтын захиргаадын нэр	Сумын нэр	Хушны самар бэлтгэх зориулалт
1	Архангай	Жаргалант	ахуйн
2	Баян-Өлгий	Цэнгэл	ахуйн
3	Сэлэнгэ	Баруунбүрэн	ахуйн
4	Хөвсгөл	Жаргалант	ахуйн
		Галт	
		Тариалан	
5	Хан Хөхийн нурууны Байгалийн цогцолборт газар	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зөвшөөрөгдсөн бүсийн ойн санд	ахуйн

ОЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР